

**ШҮҮХИЙН ШИЙДВЭРИЙН ХУРААНГУЙ****(Иргэний эрх зүйн маргаан)<sup>1</sup>****НАС БАРСАН ЗЭЭЛДЭГЧИЙН ЗЭЭЛИЙН ГЭРЭЭНД ХАМТРАН ҮҮРЭГ  
ГҮЙЦЭТГЭГЧЭЭР ОРОЛЦООГУЙ, ТҮҮНЭЭС ӨВ ХҮЛЭЭН АВААГУЙ ХАМТРАН  
АМЬДРАГЧ НЬ ТҮҮНИЙ ЗЭЭЛИЙН ҮЛДЭГДЛИЙГ ТӨЛӨХ ҮҮРЭГГҮЙ**

**САНАМЖ:** Энэхүү хураангуй нь шүүхийн шийдвэрийг орлохгүй ба хууль хэрэглээний нэгдмэл байдлыг тогтооход дэмжлэг үзүүлэх, шүүхийн шийдвэрийн үндэслэлийг сурталчлах болон иргэд, олон нийтийн эрх зүйн мэдлэгт зориулсан бөгөөд хураангуйд ашигласан шийдвэр нь хяналтын шатны шүүхийн тогтоол болно.

**Шүүхийн шийдвэрийн дугаар:** 001/ХТ2026/00038**Шүүхийн шийдвэрийн огноо:** 2026 оны 02 сарын 03 өдөр

**Шийдвэрийн төлөв:** Хяналтын шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэр, давж заалдах шатны шүүхийн магадлалыг тус тус хүчингүй болгож, нэхэмжлэгчийн нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, хариуцагчийн хяналтын журмаар гаргасан гомдлыг хангаж шийдвэрлэсэн.

**ХЭРГИЙН ТУХАЙ ТОВЧ**

Нэхэмжлэгч “ГБ” ХК нь хариуцагч С.О-д холбогдуулан зээлийн гэрээний үүрэгт 17,165,758 төгрөг гаргуулах нэхэмжлэл гаргаж, үндэслэлээ “...2016.12.06-ны өдөр Ц.М-тэй зээлийн гэрээ байгуулж 10,600,000 төгрөгийг 36 сарын хугацаатай, жилийн 19,2 хувийн хүүтэй олгосон ба 2017.12.14-ний өдөр уг гэрээнд өөрчлөлт оруулан 7,000,000 төгрөг нэмж олгосноор зээлийн хугацаа 48 сар, үлдэгдэл 14,744,923 төгрөг болсон. Зээлээ төлөхгүй байсан тул шүүхэд хандаж, эрэн сурвалжлуулсан, зээлдэгч 2019.11.25-ны өдөр нас барсан болохыг мэдсэн бөгөөд 2024.12.28-ны өдрийн байдлаар үндсэн зээл, хүү, нэмэгдүүлсэн хүү нийт 17,165,758 төгрөгийг гаргуулахыг хамтран амьдрагч С.О-с Иргэний хуулийн 189 дүгээр зүйлийн 189.1<sup>2</sup>, 451 дүгээр зүйлийн 451.1<sup>3</sup>, 520 дугаар зүйлийн 520.1<sup>4</sup>, 515 дугаар зүйлийн 515.2<sup>5</sup> дахь хэсэгт заасныг үндэслэн шаардлага гаргаж байгаа...” гэжээ.

Хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг эс зөвшөөрч, “...Ц.М-тэй 2010-2018 он хүртэл хамт амьдарсан боловч дундаасаа хүүхэдгүй, хамтран өмчлөх дундын өмч хөрөнгөгүй, гэрлэлтээ бүртгүүлээгүй, зээлийн гэрээний хамтран зээлдэгчээр

<sup>1</sup> Шүүхийн шийдвэрийг бүрэн эхээр үзэх холбоос: [https://shuukh.mn/single\\_case/11030?daterange=2026-01-01%20-%202026-07-08&id=3&court\\_cat=1&bb=1](https://shuukh.mn/single_case/11030?daterange=2026-01-01%20-%202026-07-08&id=3&court_cat=1&bb=1)

<sup>2</sup> Иргэний хууль (2002)-ийн 189 дүгээр зүйлийн 189.1 “Гэрээний талууд хуулийн хүрээнд гэрээг чөлөөтэй байгуулах, түүний агуулгыг өөрсдөө тодорхойлох эрхтэй.”

<sup>3</sup> ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1 “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.”

<sup>4</sup> ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1 “Дор дурдсан этгээдийг хууль ёсны өвлөгч гэх бөгөөд тэдгээр нь адил хэмжээгээр өвлөх эрхтэй.”, 520.1.1. “нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх”, 520.1.2. “энэ хуулийн 520.1.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ.”

<sup>5</sup> ИХ-ийн 515 дугаар зүйлийн 515.2 “Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ.”



оролцоогүй, ямар нэгэн өв хүлээн аваагүй тул нэхэмжлэлийг хүлээн зөвшөөрөхгүй...” хэмээн маргажээ.

## ХУУЛЬ ХЭРЭГЛЭЭ, ШҮҮХИЙН ШИЙДВЭР

1. **Анхан шатны шүүх:** нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэхдээ; “...талуудын хооронд зээлийн гэрээ байгуулагдаагүй тул нэхэмжлэгч нь С.О-с зээлийн гэрээний үүрэг, зээлийн хүү, нэмэгдүүлсэн хүү шаардах эрхгүй. Харин Ц.М, С.О нар 2010-2018 он хүртэл хамт амьдрах хугацаандаа 2015 онд хашаа, байшин, газар худалдан авч С.О-н нэр дээр бүртгүүлсэн, Ц.М 2016 онд гэртээ тавилга авах зорилгоор зээл авч, уг зээлийн мөнгөөр авсан тавилга одоо ч хариуцагчийн эзэмшилд байгаа, 2017 онд хашаа, байшингаа засварлах зорилгоор зээл авсан тул хашаа, байшин, газрыг Ц.М, С.О нарын дундын өмч гэж үзнэ, дундаа хэсгээр өмчлөгч нь өөрт ногдох үр шимийг өмчлөх эрхтэй тул С.О, Ц.М-н авсан зээлийн дүнгийн 50 хувийн өмчлөгч болох юм. Зээлийн төлбөрт Ц.М нь 2018.04.10-ны өдрийг хүртэл 6,450,272 төгрөг төлсөн тул үндсэн зээлийн төлбөрөөс уг дүнг хасаж, үлдэх төлбөрийн тал хувийг С.О-с гаргуулах нь зүйтэй...” гэж дүгнэсэн. (9)<sup>6</sup>
2. **Давж заалдах шатны шүүх:** шийдвэрт өөрчлөлт оруулахдаа “...анхан шатны шүүх Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1<sup>7</sup>-д заасан үндэслэлгүй хөрөнгөжсөн гэж эрх зүйн харилцааг буруу тодорхойлсон, хариуцагч нь өв хүлээн авсан гэх байдал хэргийн баримтаар тогтоогдоогүй, анхан шатны шүүх хариуцагчаас 6,931,315.26 төгрөг гаргуулж шийдвэрлэсэн шийдэлд хариуцагч давж заалдах гомдол гаргаагүй...” гэж дүгнэн нэхэмжлэлийн зарим хэсгийг хангасан шийдлийг хэвээр үлдээсэн байна. (9)
3. **Хяналтын шатны шүүх:** Иргэний хуулийн 42 дугаар зүйлийн 42.1 дэх хэсэгт зааснаар хэлцлийг хуульд заасан хэлбэрээр, мөн хуулийн 451 дүгээр зүйлийн 451.2 дахь хэсэгт заасны дагуу банкнаас олгох зээлийн гэрээг бичгээр байгуулна. Энэхүү бичгийн **гэрээнд хүсэл зоригоо илэрхийлэгч этгээд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болдог.** “ГБ” ХК-ийн нэхэмжлэлийн шаардлагын үндэслэл болгосон 2016.12.06-ны өдөр зээлийн гэрээ болон түүнд өөрчлөлт оруулсан 2017.12.14-ний өдрийн зээлийн **гэрээнд хариуцагч С.О гарын үсэг зураагүй буюу үүргийг хамтран гүйцэтгэхээр оролцсон баримтгүй** тул нэхэмжлэгч Иргэний хуулийн 451 дүгээр зүйлийн 451.1<sup>8</sup>, 242 дугаар зүйлийн 242.3<sup>9</sup>-т зааснаар **үүргийн гүйцэтгэлийг түүнээс шаардах эрх зүйн үндэслэл байхгүй.**(13)
4. **Хариуцагч С.О зээлдэгч Ц.М-тэй гэрлэлтээ батлуулаагүй, хамтран амьдарч байсан** нь Иргэний хуулийн 520 дугаар зүйлийн 520.1.1-д заасан эхнэр буюу хууль ёсны өвлөгчид хамаарахгүйгээс гадна **МНТ-н лавлагаагаар өвлүүлэгчид өвлөгдөх хөрөнгө байхгүй, өвлөх эрхийн гэрчилгээ олгогдоогүй**

<sup>6</sup> “Хууль хэрэглээ, шүүхийн шийдвэр” хэсгийн өгүүлбэрийн төгсгөлд бичигдсэн хаалт доторх дугаарлалт нь шүүхийн эх шийдвэрийн цогцолборын дугаар болно.

<sup>7</sup> ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1 “Бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэхээр хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд уг зүйлийг олж авсан этгээдээс дээрх хөрөнгөө хөрөнгө олж авсан этгээд болон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг үүсээгүй, эсхүл үүрэг нь хожим дуусгавар болсон буюу хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд буцаан шаардах эрхтэй.”

<sup>8</sup> ИХ-ийн 451 дүгээр зүйлийн 451.1 “Банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээс зээл олгох гэрээгээр банк, зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд /цаашид “зээлдүүлэгч” гэх/ нь мөнгөн хөрөнгийг хуульд заасан үндэслэл, журмын дагуу тодорхой хугацаатайгаар, зээлдэгчид шилжүүлэх, зээлдэгч нь гэрээнд заасан хугацаанд уг мөнгөн хөрөнгө, гэрээнд заасан бол түүний хүүг буцаан төлөх үүргийг тус тус хүлээнэ.”

<sup>9</sup> ИХ-ийн 242 дугаар зүйлийн 242.3 “Үүрэг гүйцэтгүүлэгч нь өөрийн үзэмжээр аль ч үүрэг гүйцэтгэгчээс үүргийн гүйцэтгэлийг бүхэлд нь буюу хэсэгчлэн шаардаж болох бөгөөд үүргийг бүхэлд нь гүйцэтгэх хүртэл үүрэг гүйцэтгэгчдийн хүлээсэн үүрэг хүчин төгөлдөр хэвээр байна.”



- болох нь тогтоогдсон байх тул мөн хуулийн 515 дугаар зүйлийн 515.2<sup>10</sup>, 520 дугаар зүйлийн 520.1.1<sup>11</sup>, 535 дугаар зүйлийн 535.1<sup>12</sup> дэх хэсэгт зааснаар нэхэмжлэлийн шаардлагыг хангах үндэслэлгүй болно. (15)
5. Анхан шатны шүүх хэргийн үйл баримтад Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1<sup>13</sup>-д заасан зохицуулалтыг буруу тайлбарлан хэрэглэснийг давж заалдах шатны шүүх нэхэмжлэгч нь өвлөгдөх хөрөнгийн хэмжээгээр хариуцагч нь нас барагчийн хүлээх үүргийг хариуцах эсэх талаар нэхэмжлэлийн шаардлагын үндэслэлийг тодорхойлсон гэж үзэн энэ хүрээнд дүгнэлт хийсэн нь зөв боловч нэхэмжлэлийн шаардлагын зарим хэсгийг хангаж шийдвэрлэснийг хэвээр үлдээсэн нь буруу байна. (16)
6. Мөн анхан шатны шүүх хариуцагчийг зээлийн мөнгөн хөрөнгийг зээлдэгчтэй хамтран захиран зарцуулсан нь Иргэний хуулийн 108 дугаар зүйлийн 108.1<sup>14</sup> дэх хэсэгт заасан дундын өмчийн хэлбэрт хамаарна гэж үзэж, улмаар авсан зээлийн 50 хувийн өмчлөгчийн хувьд Иргэний хуулийн 492 дугаар зүйлийн 492.1.1-д зааснаар зээлийн үүргийн зарим хэсгийг хариуцуулсан нь хууль зүйн үндэслэлгүй болжээ. Учир нь зээлийн гэрээний зүйл болох мөнгөн хөрөнгө нь хуваагдах боломжтой хөрөнгө тул түүнийг дундаа өмчлөх боломжгүй, зээлийн мөнгөн хөрөнгөөр худалдан авсан байж болзошгүй зүйлсийг дундаа өмчлөх нь зээлийн гэрээний үүргийг хамтран хариуцах үндэслэл болох тухайд хуульд зохицуулаагүй. (17)
7. “Хэдийгээр хариуцагч С.О анхан шатны шүүхийн шийдвэрт гомдол гаргаагүй боловч магадлалын хууль хэрэглээний талаар буюу Иргэний хуулийн 535 дугаар зүйлийн 535.1 дэх хэсэгт<sup>15</sup> заасныг хэрэглэж, түүнийг өвлөгч гэж үзсэн талаар хяналтын журмаар гомдол гаргасан тул хууль хэрэглээний нэгдмэл байдлыг хангах үүднээс шийдвэр, магадлалыг хүчингүй болгож, “ГБ” ХК-ийн нэхэмжлэлийг хэрэгсэхгүй болгох нь зүйтэй” гэж шийдвэрлэжээ. (18)

---oOo---

<sup>10</sup> ИХ-ийн 515 дугаар зүйлийн 515.2 “Өвлөгч өвлөн авсан өвийн хэмжээгээр өвлүүлэгчийн үүргийг хүлээнэ.”

<sup>11</sup> ИХ-ийн 520 дугаар зүйлийн 520.1 “Дор дурдсан этгээдийг хууль ёсны өвлөгч гэх бөгөөд тэдгээр нь адил хэмжээгээр өвлөх эрхтэй. 520.1.1.нас барагчийн нөхөр, эхнэр, төрүүлсэн болон үрчилж авсан, түүнийг нас барсан хойно төрсөн хүүхэд, нас барагчийн төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх; 520.1.2.энэ хуулийн 520.1.1-д заасан өвлөгч байхгүй, эсхүл тэдгээр нь өвлөхөөс татгалзсан буюу өвлөх эрхээ алдсан бол нас барагчийн өвөг эцэг, эмэг эх, ах, эгч, дүү, ач, зээ.”

<sup>12</sup> ИХ-ийн 535 дугаар зүйлийн 535.1 “Өв хүлээн авсан өвлөгч буюу энэ бүлэгт заасан журмаар эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллага нь өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээнд хүлээнэ.”

<sup>13</sup> ИХ-ийн 492 дугаар зүйлийн 492.1.1 “Бусдын өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэхээр хэн нэгэн этгээдэд хөрөнгө шилжүүлсэн этгээд уг зүйлийг олж авсан этгээдээс дээрх хөрөнгөө хөрөнгө олж авсан этгээд болон үүрэг гүйцэтгэгч этгээдийн хооронд үүрэг үүсээгүй, эсхүл үүрэг нь хожим дуусгаар болсон буюу хүчин төгөлдөр бус болсон тохиолдолд буцаан шаардах эрхтэй.”

<sup>14</sup> ИХ-ийн 108 дугаар зүйлийн 108.1 “Хуульд зааснаар, эсхүл хэлцлийн үндсэн дээр хоёр буюу түүнээс дээш этгээд хөрөнгийг дундаа хэсгээр буюу хамтран өмчилж болно.”

<sup>15</sup> ИХ-ийн 535 дугаар зүйлийн 535.1 “Өв хүлээн авсан өвлөгч буюу энэ бүлэгт заасан журмаар эд хөрөнгийг шилжүүлэн авсан төрийн байгууллага нь өвлүүлэгчийн гүйцэтгэвэл зохих үүргийг өвлөн авсан эд хөрөнгийн хэмжээнд хүлээнэ.”